

**Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын
Авлигын эсрэг сүлжээнээс Монгол Улсад өгсөн
зөвлөмжийн түүвэр**

/Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар/

Зөвлөмж 13

1. Улсын төсвөөс санхүүждэг төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүд, эсхүл төрийн үйл ажиллагаа эрхлэн явуулдаг байгууллагуудыг ил тод байдал болон мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамруулах нөхцөлийг бүрдүүлэх.

Зөвлөмж 15

1. Аж ахуйн нэгжүүдэд авлигын эсрэг үр дүнтэй комплианс хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх түлхэц, урамшуулал өгөх.

2. Ил тод, тооцоо бүртгэлтэй зарчмын шаардлага болон шударга байдлыг сахиулах дүрмийн үйлчлэх хүрээнд төрийн сангуудыг хамруулах нөхцлийг хангаж, хэрэгжилтийг зохих ёсоор хангах.

5. Төрийн болон ороннутгийн өмчийн үйлдвэрийн газруудад компанийн засаглал, ил тод байдал, дотоод хяналт, авлигаас урьдчилан сэгийлэх тогтолцоог бэхжүүлэх үе шаттай арга хэмжээг авч эхлэх. Төрийн өмчит үйлдвэрийн газруудын авлигын эсрэг хөтөлбөрт хяналт тавих, үнэлгээ хийх тогтолцоог бий болгох. Тухайн салбарын онцлог, авлигын эрсдлийг харгалзан үзэж, төрийн өмчит үйлдвэрийн газруудын авлигын эсрэг үйл ажиллагааны хэрэгжилтийн үр нөлөөтэй байдлыг хангах.

7. Бизнесийн омбудсмен гэх мэт хараат бус байгууллагаар дамжуулж, авлигыг мэдээлэх баталгаат сувгийг бий болгож, ашиглах.

9. Жинхэнэ өмчлөгч, ТУЗ-ийн чиг зэрэг, аудитын мэдээллийг нээлттэй мэдээлэх зэргээр компанийн засаглалын бодлогод бизнесийн шударга байдлын арга хэмжээг нэвтрүүлэх.